

**Баян-Өлгий аймгийн Статистикийн хэлтсийн ахлах  
мэргэжилтэн Хантарбайн Рысын  
ажил байдлын тодорхойлолт**

Х.Рыс нь 1960 онд төрсөн. Эмэгтэй.54 настай ам бүл 5, Ерөнхий боловсролын сургуулийг 1980 онд төгсөж, Улаанбаатар хотод Монгол улсын их сургуулийн Статистикийн ангид элсэн орж 1984 онд тус сургуулийг Статистикч-эдийн засагч мэргэжилээр төгссөн.

1984 оны 7-р сараас Баян-Өлгий аймгийн Нийтийн ахуй үйлчилгээний газарт ня-бо, 1985 оны 3-р сараар АДХГЗ-ны Зохион зааварлах хэлтэст зааварлагчаар ажиллаж байгаад 1985 оны 7-р сараас Статистикийн хэлтэст салбар хариуцсан мэргэжилтэнээр орж, Статистикийн байгууллагад 30 дахь жилдээ ажиллаж байна.1989 онд аймгийн төлөвлөгөө эдийн засгийн хэлтэсийн статистикийн албанд салбар хариуцсан статистикчээр ажиллаж,хариуцсан салбарын мэдээ тайланг цаг хугацаанд үнэн зөв гаргаж улсад мэдээлэх,тухайн салбарт анхан шатны бүртгэл нэвтрүүлэх,мэдээ тайлангийн ирцийг бүртгэх хяналтын карт,самбар нээж ажиллах талаар шинэ санаачилгаа гарган ажилдаа мөрдөж амжилтанд хүрч байсан.1995 онд санхүү эдийн засгийн хэлтсийн статистикийн албанд хүн ам, аж үйлдвэрийн салбар хариуцсан мэргэжилтэнээр ажиллаж хариуцсан салбарын мэдээ тайланг графикт хугацаанд үнэн зөв гаргаж алдаа,тасалдал, хожимдолгүй 100 хувь мэдээлж,өөрийн ажилдаа статистикийн тэргүүний ажилтануудын арга туршлагауудыг байнга нэвтэрүүлэн ажиллаж ирсэн.2000 оноос одоо хүртэл аймгийн статистикийн хэлтэст ахлах мэргэжилтэнээр ажиллаж, хүн ам нийгмийн салбарын статистик мэдээ, төсөв,санхүү, банк, цагдаа зэрэг газруудын захиргааны дотоод мэдээлэл хариуцаж, салбарын албан ёсны статистикийн мэдээ тайлангуудын үнэн зөвд тогтмол хяналт тавьж,хугацаанд мэдээлэх ,аж ахуйн нэгж байгууллагын тооцоо судалгаанд хамралтын хүрээг нэмэгдүүлэх ажилдаа анхаарлаа хандуулан ажилласанаар тухайн салбарт мэдээ тайлангийн алдаа хожимдолгүй, бүрэн хамралттай ажиллаж байна.

Графикт албан ёсны мэдээ тайлангуудыг бэлтгэх,төвд дамжуулах, заавар, зөвлөмжүүдийн дагуу ажиллах талаар удирдлагын даалгаврыг мөрдөж ажиллахын хамт,хэлтсээс гарч байгаа төрөл бүрийн статистикийн мэдээлэлээр хэрэглэгчдийн эрэлт хэрэгцээг ханган хөнгөн шуурхай үйлчилгээ үзүүлэн ажиллаж ирсэн. 2004 оноос Статистикийн улсын байцаагчаар ажиллаж, хяналт шалгалтын ажлын төлөвлөгөөний дагуу 4-5 сум байгууллагад хяналт, шалгалт хийж шалган зааварлах статистикийн мэдээллийн бодит байдлыг хангах, зөрчил дутагдалыг арилгуулах ажлуудыг хийж, хэрэглэгчдэд статистик тоо мэдээллээр хангах ажлыг гүйцэтгэж, жил бүр аймгийн статистик эмхтгэлийн хэрэглэгчдийн санал хүсэлтэд нийцүүлэн дэлгэрэнгүйгээр гаргах ажлыг гардан хийж ирсэн. Үүнээс гадна аймгийн дотоодын нийт бүтээгдэхүүний тооцоонд аж ахуйн нэгжийг бүрэн хамруулах, албан бус секторын бүтээгдэхүүний тооцооны асуулга боловсруулах, цуглуулах, тархаалт хийх зэрэг ажлуудыг гардан хийснээр аймгийн дотоодын нийт бүтээгдэхүүний тооцооны үндэслэлийг сайжруулахад ихээхэн хувь нэмэр оруулж ажиллсан.

Азийн Хөгжлийн банк,Олон Улсын Хөдөлмөрийн байгууллагын санхүү,техникийн дэмжлэгтэйгээр явагдсан ажиллах хүчний түүвэр судалгааны ажилд ахлагч, хянагчаар ажилласан, Өрхийн нийгэм, эдийн засгийн түүвэр судалгааны ажлын ахлагчаар ажиллаж 3 тоологч-судлаач шинэ залуу боловсон хүчнийг өөрийн мэргэжилд болон судалгааны ажилд дагалдуулан сургасан, 2013 онд орон даяар явагдсан “нийгмийн үзүүлэлтийн

түүвэр судалгаа”-ны ахлагчаар ажилласан, хамт олны дунд нэр хүндтэй, тусархаг, оюунлаг боловсон хүчний нэг.

Төслийн болон олон улсын хандивлагч байгууллагуудын санхүүжилтээр орон нутагт тодорхой сэдэвээр хийгддэг тооллого, түүвэр судалгаануудыг чанартай хийж гүйцэтгэхэд санаачлагатай, идэвхи зүтгэл гарган ажиллаж буй хөдөлмөрч зан чанарыг үнэлж тодорхойлов.

Орон нутгийн статистикийн байгууллагуудын оролцоотойгоор явуулдаг аливаа судалгаанд идэвх чармайлт гарган оролцож, үнэн зөв мэдээлэл цуглуулахад өөрийн мэдлэгээ дайчлан ажилладаг манай тэргүүний мэргэжилтэн юм. Үүнээс гадна орон нутгийн Дотоодын нийт бүтээгдэхүүний тооцоонд төр, захиргаа, батлан хамгаалах, эрүүл мэнд, боловсрол, банк санхүүгийн байгууллагууд, нийгэм ба бие хүнд үзүүлэх үйлчилгээний салбаруудын нэмэгдэл өртгийн тооцоог гардан гүйцэтгэдэг ба албан бус секторын судалгааг төрөл бүрийн салбарын 15-20 цэгээс санал асуулгын хуудасаар цуглуулан нийт дүндээ тархааж тооцоонд оруулах, дотоодын нийт бүтээгдэхүүний аймгийн нэгтгэл гаргах ажилуудыг амжилттай гүйцэтгэж байна. Судалгаагаар ажиллах хугацаанд багийн засаг дарга нараас өрхийн бүртгэлийн дэвтрийн хөтлөлтөнд байгна хяналт тавьж, заавирчлагаа өгч ажиллаж, 2007 оноос хрэгжиж эхсэн хүн ам, өрхийн бүртгэлийн дэвтэрийн мэдээлэлийг цахим хэлбэрт хөрвүүлэх ажлыг хариуцан гүйцэтгэж, багийн засаг дарга нарт программыг зааж сургах, дадлагажуулахад ихээхэн хүчин чармайлт гарган ажласаны үр дүнд хүн амын бичиг баримтын зөрчил тодорхой хэмжээгээр арилж цахим хэлбэрт хөрвүүлэх ажил 2013 оны жилийн эцсийн байдлаар 100 хувь хүрсэн нь хариуцсан салбарын ажлын үр дүнгийн нэг үзүүлэлт юм. Х.Рысийн ажилладаг Статистикийн хэлтэс нь ажлын ололт амжилтаар системийн байгууллагуудын дотроос 2009 онд ажлаар хоёрдугаар байр, 2010 онд гуравдугаар байр, 2011 онд зургаадугаар байр, 2012 оны ажлаар тэргүүн байр, 2013 онд ажлын үр дүнгээр гуравдугаар байр эзэлж “Өргөмжлөл” мөнгөн шагналаар шагнагдахад өөрийн хувь нэмэрийг бодитой оруулсан болно.

Х.Рысын статистикийн салбарт он удаан жил үр бүтээлтэй тогтвор суурьшилтай, санаачлагатай ажиллаж буй хөдөлмөр зүтгэлийг Үндэсний статистикийн хорооноос зохих ёсоор үнэлж, дүгнэн 2007 онд БНХАУ-ын Гонг Хонг хотын статистикийн байгууллагын ажлын туршлагыг, 2011 онд Бүгд Найрамдах Солонгос Улсын статистикийн байгууллагын тэргүүн туршлагыг судлах, танилцах аялал сургалтанд оролцож ирсэн болно.

Х.Рысын ажлын амжилтыг үнэлж 2002 онд Үндэсний Статистикийн газрын Хүндэт жуух бичиг, Статистикийн албаны 75 жилийн ойгоор аймгийн Засаг даргын Хүндэт Жуух бичгээр, Статистикийн албаны 80 жилийн ойгоор “Бүртгэл статистикийн тэргүүний ажилтан” цол тэмдгээр, Их Монгол улс байгуулагдсаны 800 жилийн ойн медалиар, 2009 онд төрийн дээд шагнал “Хөдөлмөрийн хүндэт” медалиар тус тус шагнуулсан.